

**2019 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2019 оны 1 дүгээр сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас амбулаторийн үзлэг УНТЭ 25, УХТЭ 207, УГТЭ 45 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдэлтэй харьцуулахад УНТЭ 252 тохиолдлоор УГТЭ 43 тохиолдлоор буурсан байна.

УНТЭ-ийн амбулаторийн 7 кабинетэд нийт 25 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж, өмнөх сарын хүлээгдлээс 252 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:

- Бөөрний кабинет хүлээгдэлгүй байсан бол энэ сард 1 хүлээгдэл
- Мэдрэлийн кабинет 1 хүлээгдэл
- Нүдний кабинет 1 хүлээгдэл
- Нүдний даралтын кабинет 4
- Чих хамар хоолойн кабинет 1
- Дотоод шүүрлийн кабинет 1
- Хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 16 бүртгэгдэж тус бүр 1-7 хоногийн хугацаатай хүлээсэн байна.

УХТЭ-т нийт 11 кабинетэд 180 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

- Бөөр судлалын кабинет 7
- Зүрх судасны кабинет 31
- Уушигны кабинет 4
- Мэдрэл судлалын кабинет 40
- Нүдний кабинет 2
- Чих хамар хоолойн кабинет 31
- Дотоод шүүрлийн кабинет 8
- Уламжлалтын кабинет 3
- Урологийн кабинет 2
- Хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 24
- Эмэгтэйчүүдийн кабинетэд 28 үйлчлүүлэгч тус тус 1-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 252 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УГТЭ-ийн зүрх судасны кабинетэд 45 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 13 кабинетэд 401 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


ХСҮТ-ийн амбулаторийн 14 кабинетэд нийт 319 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд:

- Зүрх судасны кабинет 74


- Элэг цөс нойр булчирхайн кабинет 56
- Толгой хүзүүний мэс заслын кабинет 5
- Эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 22
- Ерөнхий мэс заслын кабинет 7
- Цээжний хөндийн мэс заслын кабинет 43
- Гепатологийн кабинет 13
- Хөнгөвчлөх 3
- Туяа эмчилгээний кабинет 19
- Хими эмчилгээний кабинет 40
- Ангиографийн кабинет 37 үйлчлүүлэгч тус бүр 1-7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 132 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ЭХЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй байна.

УНТЭ, УГТЭ-ийн 2019 оны 1-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 1-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2019 оны 1 дүгээр сард УНТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-т оношлуулахаар 155 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 9 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна.

Үүнд:

- Рентген зураг 86
- Зүрхний цахилгаан бичлэг 2
- Хэвлийн эхо 1
- Ходоодны дуран 1
- Тархины цахилгаан бичлэг 10
- MRI 19
- Бүдүүн гэдэсний дуран 19
- Зүрхний ачаалалтай сорил 1
- Урологийн оношилгооны дуран 16 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т оношлуулахаар 240 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна. Үүнд:

- Рентген зураг 80
- Зүрхний цахилгаан бичлэг 43
- Хэвлийн эхо 91
- Ходоодны дуран 12
- Допплер 13
- Нүдний уг 1 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 129 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т оношлуулахаар 124 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Үүнд:

- Рентген зураг 22
- Зүрхний цахилгаан бичлэг 23
- Хэвлийн эхо 65
- Тархины цахилгаан бичлэг 4
- Зүрхний ЭХО 5
- Допплерографи 5 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 73 үйлчлүүлэгч байна.


ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 200 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 60 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 59, 1-6 хоногийн хүлээгдэлтэй 81 үйлчлүүлэгч байна.

Үүнд: Бүдүүн шулуун гэдэсний дуран 1 үйлчлүүлэгч, маммографи 1 үйлчлүүлэгч, рентген харалт 4, уушигны дуран 3, ходоодны дуран 28, хэвлийн ЭХО 67, зүрхний цахилгаан бичлэг 36 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.


Өдөртөө үйлчлүүлсэн 60 үйлчлүүлэгч байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 198 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 94 өдөртөө, 27 үйлчлүүлэгч 1 хоног, 21 үйлчлүүлэгч 2 хоног, 47 үйлчлүүлэгч 3-6 хоног 9 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна

УНТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 1-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын оношилгооны кабинетын 2018 оны 11, 12 сар 2019 оны 1 сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/



Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2019 оны 1 дүгээр сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 714 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 75, шээсний ерөнхий шинжилгээ 46, биохими 526, бактериологийн шинжилгээ 26, иммунологийн шинжилгээ 22, сериологийн шинжилгээ 9, коагулограммын шинжилгээ 10 үйлчлүүлэгч 1-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.


Өдөртөө үйлчлүүлсэн 474 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 151 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 57, биохимийн шинжилгээ 62, бактериологийн шинжилгээ 16, иммунологийн шинжилгээ 6, коагулограммын шинжилгээ 10 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Серологи, цитологи, шээсний ерөнхий шинжилгээ хүлээгдэлгүй.

Өдөртөө үйлчлүүлсэн 119 үйлчлүүлэгч байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 1-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2019 оны 1 дүгээр сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ бүртгэн мэдээлсэн. УНТЭ, ЭХЭМҮТ -ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УХТЭ-т 1-р сард нийт 217 үйлчлүүлэгч 1 хоногоос 30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Бөөрний тасагт 30, уушигны тасагт 4, мэс заслын тасагт 104, мэдрэлийн тасагт 18, нүдний тасагт 26, уламжлалт эмчилгээний тасагт 26, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 9 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 1-р сард нийт 120 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Бөөрний тасагт 10, зүрх судасны системийн тасагт 20, уушигны тасагт 5, мэс заслын тасагт 5, мэдрэлийн тасагт 12, нүдний тасагт 13, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 9, чих хамар хоолойн тасагт 9, мэдрэлийн мэс засалд 37, үйлчлүүлэгч тус тус 1-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 1-р сард нийт 417 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хугацаанд 78 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 81 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 129 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 119 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч байна.


ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.

Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна .

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 3 үйлчлүүлэгч, 42 үйлчлүүлэгч 3-6 хоног, 96 үйлчлүүлэгч 7-14 хоног, 36 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хугацаанд нийт 173 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл



Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харъяа 11 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 63, мэдрэл 68, ахмадын эмнэлэгт 35, Хан уул дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор 64, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв 65 үйлчлүүлэгч тус бүр 1-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.


Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 1-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 1 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ


№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	2019 оны 1 сар										
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологи йн эмнэлэг
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	63	2	0	6	7	20	0	0	0	0	0
		1-3 хоног				3		1					
		3-6 хоног		2		3	2	6					
		7-14хоног	21				3	13					
		15-30 хоног	34				2						
		1 сараас дээш	8										
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	68	64	65	44	12	20	35	0	0	0	0
		1-3 хоног		24	38	18		6	15				
		3-6 хоног	19	17	21	14	10		10				
		7-14хоног	35	14	6	6	2	13	10				
		15-30 хоног	14	9		6		1					
		1 сараас дээш											
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	35	0	0	0	0	14	0	0	0	0	0
		1-3 хоног						6					
		3-6 хоног						8					
		7-14хоног	30										
		15-30 хоног	5										
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
6	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
7	Наркологи тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	11
		1-3 хоног											11
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 1 дүгээр сард 39742 дуудлага бүртгэгдэж, өмнөх сарын дуудлагаас 12163 дуудлагаар нэмэгдсэн байна. Үүнээс: 29.1%-ийг 0-20 минутад, 30.1%-ийг 21-40 минутад, 19.3%-ийг 41-60 минутад, 21.6%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2018 оны 11, 12 сар, 2019 оны 1 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



Нийслэлийн түргэн тусламжийн төвд сүүлийн 6 сарын хугацаанд ирсэн нийт дуудлагын тоо:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА